



Хүний сайн сайхан байдал ба ус, чийг бүхий намгархаг газрын тухай Чангвоны тунхаглал

ТА ЯАГААД ЭНЭХҮҮ ТУНХАГЛАЛЫГ УНШИЖ, АШИГЛАХ ЁСТОЙ ВЭ?

Ус, чийг бүхий намгархаг газар нь хүн амын хүнсний хангамж, нүүрсхүчлийг шингээх үйлчилгээ, усны шувуудын амьдрах орчин болох, эрчим хүчийг хадгалах, биологийн олон янз байдал зэрэгт маш чухал ач холбогдолтой газар нутаг юм. Ус, чийг бүхий намгархаг газар нь хүн амын амьжиргаанд маш чухал үр ашигтай тул тэр нь хүн төрөлхтөний ирээдүйн амьдралын баталгаа болно. Тиймээс ус, чийг бүхий намгархаг газрыг хамгаалах, түүнийг ухаалгаар ашиглах явдал нь хүмүүс бидэнд ялангуяа хүн амын ядуу давхаргад амин чухал хэрэгтэй юм.

Бид хүрээлэн буй экосистемээс хүртэж байгаа үр өгөөжөөс ихээхэн хамааралтай байдаг бөгөөд эдгээрийн заримыг ус, чийг бүхий эрүүл намгархаг газар бүрдүүлж бий болгож байдаг юм. Олон улсын ач холбогдол бүхий ус, чийг бүхий намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц /РАМСАР/-ийн хүрээнд дэлхийн олон улс орнуудын хийж буй энэхүү зөвшилцөл нь бүхий л түвшний бодлого боловсруулах, менежмент явуулах үйл ажиллагаанд ус, чийг бүхий намгархаг газрыг хамгаалах, түүнийг зохистой, ухаалгаар ашиглах асуудлыг анхаарч оруулахад ихээхэн хувь нэмэр оруулах учиртай. Улмаар бид бүгд ус, чийг бүхий намгархаг газрыг хамгаалах, эрүүл ухаантайгаар ашиглахын ач тус, хүний сайн сайхан байдлыг бий болгоход ус, чийг бүхий намгархаг газрын үзүүлэх үр өгөөж /ус, нүүрстөрөгчийг шингээх, хоол хүнс, эрчим хүч, биологийн олон янз байдал, хүн амын амьжиргааны баталгаа болдог/-ийг бид бүхэн ухамсарлаж ойлгосон мэдлэг, мэдээлэлтэй болж, тэдгээрийг бодит байдалд

ашиглахад дөхөм болгож боловсруулсан удирдамж, загвар, мэдээллийн сүлжээг бий болгох шаардлагатай байна.

Чангвоны тунхаглал бол дэлхийн улс орнуудын хөгжлийн тэргүүлэх чиглэл болж буй “Байгаль орчны тогтвортой байдал”-ын зорилгод улс орнууд “хэрхэн” хамтдаа хүрэхийг харуулсан үйл ажиллагааны алхамуудын талаархи баримт бичиг юм.

2008 оны 10 дугаар сарын 28-наас 11 дүгээр сарын 4-ний өдрүүдэд БНСолонгос Улсад зохион байгуулагдсан РАМСАР-ын Конвенцийн Талуудын 10-р бага хурлаас гарсан шийдвэр, үйл ажиллагаануудыг “Чангвоны тунхаглал” хэмээн зарлан тунхаглаж, улс орнууд бодлого, төлөвлөлтөндөө оруулж, хэрэгжүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

Чангвоны тунхаглал бол хүрээлэн буй орчныхоо хойч ирээдүйд анхаарч, санаа зовниж явдаг хүн бүгдэд хамааралтай.

Хэрэв Та байгаль орчин, газар, байгалийн нөөцийн ашиглалтын салбаруудад төлөвлөгч, бодлого боловсруулагч, ард түмнээсээ сонгогдсон төлөөлөгч, менежер бол эсвэл боловсрол, холбоо харилцаа, хүн амын эрүүл мэнд, эдийн засаг, амьжиргааны салбаруудад ажилладаг бол энэхүү тунхаглал нь Таньд шууд зориулагдсан байна. Таны хийж буй үйл ажиллагаа, үйлдэл тань ус, намгархаг газрын ирээдүйд нөлөөлөх болно.

Энэ тунхаглал хаанаас гарсан бэ?

Олон улсын ач холбогдол бүхий ус, чийг бүхий намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц /РАМСАР/ бол манай гаригийн ус, чийг бүхий намгархаг газрыг хамгаалах, түүнийг ухаалгаар ашиглах асуудлыг анхаарч үздэг дэлхийн улс орнуудын боловсруулсан хамтын хэлэлцээр юм. 1971 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Иран улсын Рамсар хотод¹ энэхүү хэлэлцээрийг байгуулжээ. Энэхүү конвенцийн зорилго нь:

“Бүхий л түвшний ус, чийг бүхий намгархаг газрыг² хамгаалах, эрүүл, ухаалгаар ашиглахад³ чиглэгдсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх замаар дэлхийн улс орнуудад тогтвортой хөгжлийг бий болгоход хувь нэмэр оруулах явдал юм”.

Конвенцийн Талуудын 10-р бага хурал “Эрүүл ус, чийг бүхий намгархаг газар ба эрүүл хүн”⁴ сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан бөгөөд хүний сайн сайхан байдал ба ус, чийг бүхий намгархаг газрын салшгүй уялдаа холбоог тодорхойлж, эрүүл ус, чийг бүхий намгархаг газрыг хамгаалах, бий болгох чиглэлээр авч хэрэгжүүлэх “эерэг” үйл хэргийг тодорхойлоход чиглэгдсэн байна.

Энэ тунхаглалыг хэн ашиглах вэ?

Талуудын бага хурлаар энэхүү тунхаглалыг ашиглагч нь байгаль орчны удирдлага, менежментэд холбогдох бүхий л талууд, ялангуяа дэлхийн түвшний удирдагчид болох Засгийн газрын тэргүүнүүд мөн орон нутгийн болон гол мөрний сав газрын түвшний удирдагчид байна гэжээ.

Энэ нь яагаад ”зүгээр л нэг энгийн тунхаглал” биш вэ?

Дэлхийн түвшинд зохион байгуулагдсан байгаль орчны чиглэлийн олон хурлуудаас маш олон тунхаглал гардаг. Харин “Чангвоны тунхаглал” бол бусад тунхаглалуудаас өөр, “стандарт” бус, өөрийн гэсэн өвөрмөц байдлыг хадгалсан, үнэ цэнэ бүхий баримт бичиг юм:

- Энэ нь РАМСАР-ын конвенцид холбогдох улс орнуудад үйл хэрэг болгох боломжийг олгох зорилгоор шууд зориулагдсан
- Эерэг, бодит байдалд нийцсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг санал болгосон
- Тунхаглалыг хэрэгжүүлж эхлэхэд гарах нөлөөллийг давхар тодорхойлсон болно.

Энэхүү тунхаглал юуг өгүүлж байна вэ?

Хүний сайн сайхан байдлыг бүрдүүлж, хангахын тулд хийвэл зохих “эерэг” үйл хэргүүдийг тодотгон “Чангвоны тунхаглал”-д тусгасан ба үүнд доор дурьдсан 5 үндсэн тэргүүлэх үйл хэрэг, тэдгээрийг түгээн дэлгэрүүлэх салбар дундын 2 түлхүүр механизмыг оруулсан байна.

УС БА УС, ЧИЙГ БҮХИЙ НАМГАРХАГ ГАЗАР

Газар ашиглалт, гол мөрний гольдролыг өөрчлөх үйл ажиллагаа, дэд бүтцийн хөгжлийн нөлөөний улмаас ус, чийг бүхий намгархаг газар бусад экосистемүүдээс илүүтэйгээр доройтож, ширгэж байгаа ба цаашид ч мөн улам ихээр өртөх нь ажиглагдаж байна. Дэлхийн 1-2 тэрбум хүнд цэвэр ус хэрэглэх боломж буурч байгаа нь хүнс тэжээлийн үйлдвэрлэл, хүн амын эрүүл мэнд, эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлөх болж улмаар нийгмийн зөрчлийг үүсгэнэ.

Усны нөөцийн удирдлагыг сайжруулах хэрэгцээ нэн тэргүүнд тулгамдаж байна. Шаардлагатай хэмжээгээрээ ус, чийг бүхий намгархаг газрын усыг хуваарилж, хэрэглэхийн оронд түүнийг “Байгалийн усны дэд бүтэц” хэмээн

онцолж, гол мөрний сав газрын түвшинд ус, чийг бүхий намгархаг газрыг усны нөөцийн менежментэд нэгтгэн оруулж, усны нөөцийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатай.

“ Жирийн л бизнес” гэдэг ойлголт, хувилбараас татгалзах учиртай.

Бидний өсөн нэмэгдэж буй усны хэрэгцээ шаардлага, хэрэгцээнийхээ хэрээр хэрэглэж буй усны өнөөгийн хэт их хэрэглээ нь хүний сайн сайхан байдал, хүрээлэн буй байгаль орчинд аюул занал учруулж байна. Усны бодит хэрэгцээ шаардлага, түүнийг хуваарилах хангамжийн хооронд үүсэх “цоорхой” эрчимтэй нэмэгдсэний улмаас ус, чийг бүхий намгархаг газар доройтож, улмаар цэвэр ус хэрэглэх боломж, хүний сайн сайхан амьдрал, хүнс тэжээлийн үйлдвэрлэл, эдийн засгийн хөгжил, геополитикийн тогтвортой байдал алдагдахад хүрч байна.

Хүний хэрэгцээг бүрэн хангах, ус, чийг бүхий намгархаг газрыг бүрэн нөхөн сэргээх, сайжруулах хангалттай хэмжээний ус байхгүй. Голын урсац, гольдролыг засах, ус, чийг бүхий намгархаг газрыг нөхөн сэргээх чиглэлийн оролдлого, ажлуудын тоо хэмжээ, далайц нь буурч байна. Экосистемд усыг хуваарилах буюу байгалийн урсац, гольдролыг дэмжих, усны хуваарилалтын хязгаарыг /”усны цоорхой”/ тогтоох, усны менежментийн шинэ хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.

“Усны цоорхой”-г нөхөхийн тулд бид дараах зүйлсийг хийх хэрэгтэй байна:

- **Байгаа усаа илүү их үр ашигтай ашиглах;**
- **Ус, чийг бүхий намгархаг газрын доройтол, ширгэлтийг зогсоох**– “усны аюулгүй байдал бол эрүүл ус, чийг бүхий намгархаг газар юм” гэдгийг онцлон тэмдэглэж, ус, чийг бүхий намгархаг газар нь бусад экосистемээс илүү их хурдацтай устах аюулд орж, доройтож байна гэдгийг ухамсарласны үндсэн дээр;
- **Нэгэнт доройтсон ус, чийг бүхий намгархаг газрыг нөхөн сэргээх** – энэ нь газрын доорхи болон гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх, усны чанарыг сайжруулах, хөдөө аж ахуй, загасны аж ахуйг хамгаалах, биологийн олон янз байдлыг хамгаалах өртөг зардлын үр ашигтай арга зам болно.
- **Ус, чийг бүхий намгархаг газрын ухаалаг менежмент, хамгаалал** – хүнс тэжээл үйлдвэрлэх, бидний унд, ахуйн ариун цэврийн усны хэрэгцээг хангахад шаардагдах усны эх үүсвэртэй /чанар ба тоон хувь/ байх байдлыг хангах замаар. **Ус, чийг бүхий намгархаг газар нь бидний хувьд хялбар дөт замаар хүртэж болох цэвэр усны цорын ганц эх үүсвэр учраас** хэрэв бид жаахан л алдаа гаргавал бидэнд тулгамдаж буй цэвэр усны хомсдолын асуудал маань улам даамжрах аюултай юм.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА УС, ЧИЙГ БҮХИЙ НАМГАРХАГ ГАЗАР

Ус, чийг бүхий намгархаг газар нь нүүрстөрөгчийг өөртөө шингээж, хуримтлуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Ус, чийг бүхий намгархаг газар нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд маш эмзэг бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, хүний сөрөг үйл ажиллагааны улмаас ширгэсэн ус, чийг бүхий намгархаг газраас асар их нүүрсхүчлийн хийн ялгарал явагдана.

Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах байгалийн дэд бүтцийн нэг чухал хэсэг бол ус, чийг бүхий намгархаг газар юм. Ус, чийг бүхий намгархаг газрын доройтол, ширгэлтийн улмаас хүн ам уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд улам бүр нэрвэгдэх магадлал өснө. Тухайлбал, хоол хүнсний хомсдол, ган зуд, өлсгөлөн бий болно. Дэлхийн улс орнуудын уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох бодлого нь усыг хадгалах, шилжүүлэх мөн түүнийг эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглахад чиглэгдэж байна. Хэрэв эдгээр бодлогыг муу хэрэгжүүлбэл ус, чийг бүхий намгархаг газарт сөргөөр нөлөөлж, доройтуулах болзошгүй.

Усны менежментийн хүрээн дэх уур амьсгалын өөрчлөлт бидний тооцоолсноос илүү ихээр нэмэгдсэн нь усны хэрэгцээ шаардлага, хангамжийн хоорондох “цоорхой”-г нөхөх асуудлыг шийдвэрлэхэд улам бүр төвөгтэй болж байна. Уур амьсгалын өөрчлөлт нь усны хуваарилалт, цэвэр усны боломжит нөөцөд шууд сөргөөр нөлөөлж байна гэдгийг бид мэдэрч байна. Энэ нь эрүүл ус, чийг бүхий намгархаг газарт мөн сөргөөр нөлөөлж байна. Ус, чийг бүхий намгархаг газрыг нөхөн сэргээх, гадаргын усны эргэлтийг сайжруулах нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг багасгаж, үерийн давтамжийг бууруулах, ус, хоол хүнсний хангамж, биологийн олон янз байдлыг хамгаалахын маш чухал алхам болох юм.

Далайн түвшин нэмэгдэх үзэгдлийг багасгах стратегид эргийн дагуух ус, чийг бүхий намгархаг газрууд нь маш чухал үүрэгтэй.

Улс орны түвшинд Засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах үр ашигтай стратеги боловсруулахдаа ус, чийг бүхий намгархаг газрын менежментийг заавал тооцож үзэх шаардлагатай юм. Шийдвэр гаргагчид уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох, тэмцэхэд маш чухал байгалийн дэд бүтэц нь ус, чийг бүхий намгархаг газар юм гэдгийг ухамсарлаж ойлгох хэрэгтэй.

Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, уур амьсгалын байгалийн үйл явцыг зохицуулахад ус ба ус, чийг бүхий намгархаг газар нь үндсэн үүрэг

гүйцэтгэнэ /усны эргэлт, биологийн олон янз байдалд дэмжлэг үзүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, сөрөг нөлөөллийг хязгаарлан барих замаар/. Ус, чийг бүхий намгархаг газрыг хамгаалж, ухаалгаар ашиглах нь эдийн засаг, нийгэм, экологид уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг багасгаж болох юм.

Ялангуяа ус, чийг бүхий намгархаг газар, уур амьсгалын уялдаа холбооны **дүн шинжилгээ хийх**, ойлголт, мэдлэг мэдээллээ **харилцан солилцох** зорилгоор **Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх олон улсын техникийн талуудын хамтын ажиллагааг өргөжүүлж хөгжүүлэх** /тухайлбал: уур амьсгалын өөрчлөлтийн Засгийн газар хоорондын зөвлөл, РАМСАР-ын конвенцийн шинжлэх ухаан, техникийн зөвлөл/ нь нэн чухал юм.

ХҮН АМЫН АМЬЖИРГАА БА УС, ЧИЙГ БҮХИЙ НАМГАРХАГ ГАЗАР

Улс орны хөгжлийн салбарууд дахь бодлого, төлөвлөлт нь хоорондоо үл нийцсэн байж болохгүй. Тухайлбал: ядуурлыг бууруулахад чиглэсэн томоохон дэд бүтэц, хөгжлүүд нь ус, чийг бүхий намгархаг газрыг доройтуулдаг. Улмаар ус, чийг бүхий намгархаг газрын ойролцоо амьдардаг орон нутгийн иргэд хоол хүнсний хомсдолд орж, харин ч ядуурал улам гүнзгийрч болзошгүй юм.

Эдийн засгийн хөгжил, хүн амын ялангуяа ядуу хүмүүсийн амьдрал, аж ахуйд ус, чийг бүхий намгархаг газрын үзүүлэх үр өгөөж, хувь нэмрийг нэмэгдүүлэх үйл хэргийг хэрэгжүүлэх. Ядуурлыг бууруулах стратеги, холбогдох бодлого, төлөвлөгөөнд ус, чийг бүхий намгархаг газрыг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг төлөвлөж оруулж байх хэрэгтэй.

Ус, чийг бүхий намгархаг газрыг ухаалгаар ашиглах, менежмент хийх, нөхөн сэргээснээр хүн амын амьжиргааг дээшлүүлэх боломж бүрдэх ба ялангуяа ус, чийг бүхий намгархаг газраас шууд хамааралтай амьдардаг эмзэг бүлгийн хүмүүсийн амьжиргаа сайжрах болно. Тиймээс ус, чийг бүхий намгархаг газрын доройтол нь хүн амын амьжиргаатай шууд холбогдож, ядуурлыг бий болгох, ялангуяа энэ нь нийгмийн эмзэг хэсэгт илүү их сөргөөр нөлөөлнө.

Ус, чийг бүхий намгархаг газрын экологийн хэв шинж⁵, хүн амын амьжиргааны харилцан уялдаанд илүү сайн дүн шинжилгээ хийж, түүнийг баримтжуулах хэрэгтэй. Бүхий л түвшинд энэхүү уялдаа холбооны талаар харилцан суралцах, мэдлэг солилцох, мэдээлэл цуглуулах боломж бүрдүүлэх зорилгоор байгууллага, боловсон хүчний чадавхи, хамтын ажиллагааг хангах учиртай.

Ус, чийг бүхий намгархаг газартай холбоотой уламжлалт, мэдлэг, соёлын зүйлсийг тодорхойлох, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хүн амын амьжиргааг дэмжих, орлогын сувгуудыг нэмэгдүүлэх замаар ус, чийг бүхий намгархаг газрын тогтвортой менежментийг хэрэгжүүлэх хэрэгтэй.

ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД БА УС, ЧИЙГ БҮХИЙ НАМГАРХАГ ГАЗАР

Ус, чийг бүхий намгархаг газар нь хүн амын эрүүл мэндэд ихээхэн эерэг үр өгөөжийг өгдөг ба энэ нь хүн амын хувьд боловсрол, эко-аялал жуулчлал, амралт, соёлын болон байгалийн сайханд амарч зугаалах газар болдогоороо ихээхэн ач холбогдолтой юм.

Ус, чийг бүхий намгархаг газрын экосистем ба хүн амын эрүүл мэнд хоёрын харилцаа холбооны тухай асуудал нь улс үндэсний болон олон улсын бодлого, төлөвлөлт, стратегийн үндсэн түлхүүр нь байх учиртай.

Улс орны хөгжлийн түлхүүр болсон уул уурхай, боловсруулах үйлдвэрүүд, дэд бүтцийн хөгжил, ус, ариун цэвэр, эрчим хүч, хөдөө аж ахуй, тээвэр зэрэг бусад салбаруудын үйл ажиллагаа нь ус, чийг бүхий намгархаг газарт шууд ба шууд бус байдлаар “сөрөг” нөлөө үзүүлдэг. Эдгээр салбарууд дахь шийдвэр гаргагчид, менежерүүд нь ус, чийг бүхий намгархаг газарт сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх, шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх арга хэмжээг бололцооны хэрээр авч хэрэгжүүлж байх хэрэгтэй.

Эрүүл мэнд, ус, чийг бүхий намгархаг газрын салбарууд нь ус, чийг бүхий намгархаг газрын экологийн хэв шинж ба хүний эрүүл мэндийн уялдаа холбоог хангах хамтын менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ус ба ус, чийг бүхий намгархаг газрын салбарын менежерүүд нь ус, чийг бүхий намгархаг газрын экосистем болон хүний эрүүл мэндийн аль алинд нь үр өгөөж өгдөг байх бодлого, үйл хэргийг хэрэгжүүлж байх хэрэгтэй. Ус, чийг бүхий намгархаг газарт үзүүлж буй гадны хүчин зүйлсийн сөрөг нөлөө нь хүний эрүүл мэндэд давхар сөргөөр нөлөөлж байна. Жнь: хүн амын ундны ус, ариун цэвэр, хоол хүнсэнд хэрэглэдэг цэвэр усны чанарын муу байдлаас үүдэлтэй өвчлөлүүд их гарч байна.

ГАЗАР АШИГЛАЛТЫН ӨӨРЧЛӨЛТ, БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ БА УС, ЧИЙГ БҮХИЙ НАМГАРХАГ ГАЗАР

Ус, чийг бүхий намгархаг газрын экосистемийг өөрчлөхөд шаардагдах өртөг, түүнээс хүртэх үр өгөөжийн талаар илүү сайн ойлголт, мэдлэгтэй байх нь

зөв зүйтэй шийдвэр гаргах үндэс болно. Газар ашиглалтын өөрчлөлттэй холбоотой аливаа шийдвэр гаргахдаа ус, чийг бүхий намгархаг газрын иргэд болон биологийн олон янз байдалд үзүүлэх үр өгөөж, тэдгээрийн үнэ цэнийн талаар хангалттай мэдлэг мэдээлэлтэй байх учиртай.

Аливаа шийдвэр гаргахдаа ус, чийг бүхий намгархаг газрын байгалийн өөрийнх нь эргэлт, үйл ажиллагааг нь аль болох алдагдуулахгүй байлгахад анхаарах учиртай.

Биологийн олон янз байдлын тоо толгой хурдацтай буурч байгааг анхаарч “2010 оны хүрэх цэг”⁶-ийг тодорхойлж, түүнд хүрэх “зорилго” болгон тавих замаар биологийн олон янз байдлын алдагдалд хүргэж буй анхдагч шалтгааныг олж шийдвэрлэх чиглэлээр ажиллах шаардлагатай.

Дээрх бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд салбар дундын ямар хоёр механизмыг хэрэгжүүлэх шаардлагатай вэ?

Төлөвлөлт, шийдвэр гаргалт, санхүү, эдийн засаг

Дээрх тунхаглалд гарсан уриаг үйл хэрэг болгоход юун түрүүнд салбар дундын бодлогыг харилцан уялдуулан зохицуулах замаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах шаардлагатай. Олон нийтийг шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулж байх учиртай. Аливаа шийдвэр гаргахдаа шийдвэр гаргах шилдэг арга хэлбэрүүд / үнэлгээ хийх, зөрчил шийдвэрлэх, шийдвэр гаргах арга ажиллагааны диаграм, өртөг-үр ашгийн анализ гэх мэт/-ийг ашиглах явдал нь тулгамдсан асуудал, шийдвэрлэх боломжуудыг тодорхойлоход маш чухал үүрэгтэй.

Төлөвлөлтийг хийхдээ ус, чийг бүхий намгархаг газрын ач холбогдлыг бүрэн тодорхойлж оруулж байх, ялангуяа олон улсын түвшинд чухалд тооцогдох ус, чийг бүхий намгархаг газрууд /РАМСАР-т бүртгэлтэй газрууд⁷/ -ыг чухалчлан оруулж, тэдгээрийн үнэ цэнийг бүрэн үнэлж мэдсэнээр аливаа газар ашиглалт, хөрөнгө оруулалт хийхэд намгархаг газрыг тэдгээрийн нэн тэргүүлэх чиглэлд оруулж, хамгаалах шаардлагатай.

Өртөг, үр ашгийн цогц дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Ус, чийг бүхий намгархаг газрын эдийн засгийн үнэлгээ, мөн ус, чийг бүхий намгархаг газрын экологийн хэв шинжийг засаж сайжруулах чиглэлийн ажлыг төлөвлөж, энэ салбарт хөрөнгө оруулснаар ус, чийг бүхий намгархаг газрыг ширгэж, доройтсоны дараа нөхөн сэргээснээс илүү их өртөг, зардлыг хэмнэх “Шилдэг стратеги” болно.

Ус, чийг бүхий намгархаг газрыг хамгаалах хангалттай, тогтвортой санхүүжилтийг бий болгох, ухаалаг ашиглалт нь маш чухал. Ус, чийг бүхий намгархаг газрын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажилладаггүй, РАМСАР-ын конвенцид нэгдэн ороогүй улс орнуудыг ус, чийг бүхий намгархаг газрыг хамгаалах үйлст татан оролцуулж, нэгдүүлэх, энэ чиглэлд хамтын ажиллагааг өргөжүүлэх, дэвшилтэт санхүүгийн хөшүүргийг ашиглах замаар ус, чийг бүхий намгархаг газрыг хамгаалах хангалттай, тогтвортой санхүүжилтийг бий болгох хэрэгтэй байна. Ялангуяа хязгаарлагдмал нөөцтэй өнөө үед ус, чийг бүхий намгархаг газрыг хамгаалах, түүнийг ухаалгаар ашиглахтай холбоотой үйл ажиллагааг бололцооны хэрээр нэмэгдүүлж, бидэнд байгаа нөөцөө үр ашигтай ашиглахыг хичээх ёстой.

Мэдлэг, туршлагаа солилцох

Ус, чийг бүхий намгархаг газрын хэв шинж, дэлхийн ус, чийг бүхий намгархаг газруудын талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагтай. Өндөр хөгжсөн мэдээллийн технологиудыг ашиглах боломж бидэнд байна.

Энэхүү тунхаглалд орсон асуудлуудтай холбоотой тоо баримт, мэдлэг, мэдээллээ /уламжлалт мэдлэг/ бусадтай солилцох сонирхолтой байгууллагууд нь харилцан хүртэж болохуйц, зүй зохистой, нэгдмэл арга хандлагыг бий болгохыг чармайн зүтгэх хэрэгтэй. Ингэснээр мэдээллийн зохистой технологийг нэвтрүүлэх замаар мэдлэг, туршлага /тухайлал: сайн туршлагыг хүлээн авах/ -аа илүү их үр дүнтэй солилцох бололцоотой болно.

Тунхаглалыг ажил хэрэг болгоход Таны оролцоо

Энэ тунхаглалд орсон асуудлуудыг үйл хэрэг болгоход бид бүгдээрээ хүчин зүтгэх хэрэгтэй. Зарим нэг бүлэг, нөхөрлөлүүд тунхаглалд заасан арга замаар ус, чийг бүхий намгархаг газрыг ухаалгаар ашиглах, хамгаалахын төлөө ажиллаж эхлээд байна. Бодитой үр дүн, ахиц дэвшил гаргахад дэмжлэг болохуйц үнэ цэнэтэй мэдлэг, мэдээлэл, туршлага бидэнд байна. Хамтдаа зүтгэе, харилцан холбоо тогтооё.

Энэхүү Тунхаглалыг амжилттай хэрэгжүүлэх арга хэмжээнүүд:

- Тунхаглалыг олон нийтэд мэдүүлэх, тайлагнах, орчуулах, үргэлж санаж байх;

- Тунхаглалд орсон зүйлсийг орон нутгийн болон голын сав газрын төлөвлөлт, шийдвэр гаргалт, менежментийн үйл ажиллагаанд оруулж байх
- Эдгээрийг мөн үндэсний түвшний төлөвлөлт, шийдвэр гаргалт, үйл ажиллагааны хөтөлбөрт уялдуулах
- Засгийн газрын төлөөлөгчид аливаа олон улсын уулзалт зөвлөлгөөнд оролцоход эдгээр асуудлуудыг хөндөж, олон улсын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах

Зүүлт:

¹ **Ус, чийг бүхий намгархаг газрын тухай РАМСАР-ын конвенц нь** хүмүүн төрөлхтөнд сайн сайхан байдлын хүчин зүйлсийг өгч байдаг орчин бол ус, чийг бүхий намгархаг газар юм гэдгийг нийгмийн бүхий л салбар, түвшинд хүлээн зөвшөөрүүлэх зорилго бүхий Засгийн газар хоорондын дээд хэлэлцээр юм.

² **“Ус, чийг бүхий намгархаг газар”** нь бид бүхний төсөөлдөгөөс ч илүү өргөн цар хүрээ бүхий экосистемийг агуулсан байдаг. РАМСАР-ын конвенцийн нэгдүгээр бүлгийн 1 дэх хэсэгт тодорхойлсноор “ус, чийг бүхий намгархаг газар гэдэг нь байгалийн ба хиймэл, байнгын ба түр зуурын, урсгал ба тогтмол, цэнгэг ба шорвог ус, намаг, балчиг, хүлэр намаг бүхий газрууд болон далайн татлагынхаа үеэр 6 метрээс илүүгүй гүнтэй далайн эргийн ус бүхий газрыг хэлнэ”.

³ Ус, чийг бүхий намгархаг газрын **“Ухаалаг ашиглалт”** гэдэг нь уг конвенцийн “тогтвортой хөгжлийн зарчмын хүрээнд ус, чийг бүхий намгархаг газрын экологийн хэв шинжийг нөхөн сэргээж, сайжруулах” гэсэн хэсгээр тодорхойлогдоно (“тогтвортой хөгжил” гэдэг ойлголтонд ус, чийг бүхий намгархаг газрыг доройтуулахгүйгээр нийгэмд үр ашиг өгөхүйц хөгжлийн алхам, шийдвэрүүдийг гаргах явдал юм).

⁴ РАМСАР-ын конвенцийн **“Талуудын бага хурал”**-аар конвенцийн хэрэгжилтэнд хийсэн үнэлгээнээс гарсан тэргүүлэх чиглэлүүдийг “сэдэвчилсэн асуудал” болгон онцлон тодорхойлдог. Өмнө нь ус, чийг бүхий намгархаг газар ба хүн хоёрын уялдаа холбооны олон янзын асуудлуудыг онцолж байсан бол Талуудын 10 дугаар Бага хурлаас “эрүүл ус, чийг намгархаг газар ба эрүүл хүн” гэсэн сэдвийг онцолж, эрүүл хүн ба эрүүл ус, чийг бүхий намгархаг газрын уялдаа холбоог ойлгон ухамсарлаж, үүнтэй холбоотой үйл ажиллагааны шинэлэг шийдвэрүүдийг гаргахыг уриалсан байна.

⁵ Ус, чийг бүхий намгархаг газрын “**Экологийн хэв шинж**” нь РАМСАР-ын конвенцийн түлхүүр ойлголт бөгөөд үүнийг “ус, чийг бүхий намгархаг газрын онцлогийг тодорхойлдог экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүд, үйл явц, үр ашгийн нийлбэр цогц” гэж тодорхойлж байна (“Экосистемийн Мянганы Үнэлгээ”-нд экосистемийн үйлчилгээг “экосистемээс авч буй хүмүүсийн үр өгөөж” хэмээн тодорхойлсны дагуу экосистемийн үр өгөөжийг ойлгоно).

⁶ Биологийн төрөл зүйлийн тухай конвенци ба 2002 оны Тогтвортой хөгжлийн асуудлаархи НҮБ-ын дэлхийн дээд хэмжээний уулзалтаар дэлхийн улс орнуудын удирдагчдын тунхагласан “**2010 оны биологийн олон янз байдлын хүрэх цэг**” гэдгийг “2010 он гэхэд дэлхийн, бүс нутгийн, улс орны түвшин дэх биологийн олон янз байдлын тоо толгойн бууралтын хувийг тодорхой хэмжээгээр багасгаснаар ядуурлыг бууруулах, дэлхий ертөнцийн бүхий л амьд организмд үр өгөөж өгөх зорилгод хувь нэмэр оруулна” хэмээн тодорхойлсон байна.

⁷ “**РАМСАР-ын жагсаалтанд орсон газрууд**” (олон улсын ач холбогдол бүхий ус, чийг бүхий намгархаг газрууд) нь РАМСАР-ын конвенцид нэгдэн орсон талуудын буюу дэлхийн улс орнуудын Засгийн газрын хүлээн зөвшөөрч, тунхагласан ус, чийг бүхий намгархаг газрууд юм. Тэдгээр нь дэлхийн хамгийн том “Тусгай Хамгаалалттай Газрууд”-ын сүлжээг бүрдүүлдэг ба одоогоор энд (2008 оны 11 сарын байдлаар) 168 сая га газар нутгийг хамарсан 1822 газар байна.